



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит

АУДИТЫН КОД: ТӨА-2025/121-ШТА-НА

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
<i>Аудит хийх үндэслэл:</i>	3
<i>Аудитын зорилт:</i>	3
Аудитын хамрах хүрээ:	3
Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:.....	3
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:	3
Аудитын арга зүй:	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:.....	3
Үндсэн мэдээлэл.....	4
Бүлэг 1. СЕХ-ны тамгын газар нь улсын төсвөөс олгох сонгуулийн зардлын төсөв болон зарцуулалтын тухай тайлбарыг албан бичгээр ирүүлж арга зүйгээр ханган ажиллажээ.....	5
СЕХ-оос ирүүлсэн санхүүжилтийг 6 сумын сонгуулийн хороонд зарцуулахаар хуваарилан олгосон байна.	5
Бүлэг 2. СЕХ-ний баталсан журмын дагуу сумдын сонгуулийн хорооны зардлын төсөв, гүйцэтгэлийг тайлагнасан байна.	6
Нөхөн сонгууль зохион байгуулалттай холбоотой батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 9,180.3 мянган төгрөгийг СЕХ-ний дансанд буцаан төвлөрүүлсэн байна.	6
ДҮГНЭЛТ	8
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	9

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Нөхөн сонгуулийн зардлын төсөв	5
Хүснэгт 2. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хуваарь	7
Хүснэгт 3. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл	7

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025.06.21-ны өдрийн А/63 дугаар тушаалыг үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит” сэдэвт аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад 6 сумын сонгуулийн хороо хамрагдсан.

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдан, аудитын менежер О.Амаржаргал үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хүрэлбаатар 2025 оны 8 дугаар сарын 01-ээс 9 дүгээр сарын 5-ыг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгаагдах мэдээлэл:

Аудитын тайлан ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичигдлээ.

Аудитад сумдын сонгуулийн хороодод улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлын зарцуулалт, санхүүгийн баримтуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 400, 4000 дугаар стандартууд, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/33 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмыг мөрдлөг болгосон.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврын холбогдох заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

Үндсэн мэдээлэл

Төв аймгийн Аргалант, Батсүмбэр, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант гэсэн 11 сумдад 2025 онд нөхөн сонгууль явагдах байсан боловч Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант гэсэн 6 сум сонгуулийн хороогоо байгуулж, үлдэх сумд байгуулаагүй байна. Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулж явуулах аймгийн сонгуулийн хороо байгуулагдаагүй байна.

АНСДИТХСТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу СЕХ-ны тамгын газрын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгээр 6 сумын сонгуулийн хороонд 139,611.6 мянган төгрөгийг батлан санхүүжүүлсэн байна.

АНСДИТХСТХ-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу 6 сумын сонгуулийн хороо, 6 хэсгийн хороонд нийт 103 төрийн албан хаагч төлөвлөгөөний дагуу оролцон ажиллажээ.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд 6 сумын 6 мандатад 14 нэр дэвшигч өрсөлдсөн байна.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 мандатын төлөө 8 нэр дэвшигч дэвшсэнээс 3 эрэгтэй, 5 эмэгтэй нэр дэвшигч оролцсон байна. Намын харьяаллаар авч үзвэл МАН-аас 6 нэр дэвшигч, АН-аас 1 нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч 1 байна.

Сонгогчдын санал авах ажиллагааг АНСДИТХСТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу СЕХ-ны 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн №01 дүгээр “Цаг хугацааны хуваарь батлах тухай” тогтоолоор 2025 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 07:00-20:00 цагийн хооронд зохион байгуулахаар баталж, зохион байгуулсан байна. Сонгуулийн тойргийн хэмжээнд сонгогчдын нэрсийн жагсаалтад санал өгөх сонгогч 4197 хүн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс 1314 буюу 31.3 хувь нь санал хураалтад оролцож санал өгсөн байна.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн үр дүнг авч үзэхэд Заамар сум 1 мандатаас МАН 1, Лүн сум 1 мандатаас МАН 1, Өндөрширээт сум 1 мандатаас МАН 1, Угтаалцайдам сум 1 мандатаас МАН 1, Эрдэнэ сум 1 мандатаас бие даан нэр дэвшигч 1, Эрдэнэсант сум 2 мандатаас МАН 2 суудал тус тус авсан байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт төсөв баталж хуваарилаагүй байна.

Бүлэг 1. СЕХ-ны Тамгын газар нь улсын төсвөөс олгох сонгуулийн зардлын төсөв болон зарцуулалтын тухай тайлбарыг албан бичгээр ирүүлж арга зүйгээр ханган ажиллажээ.

АНСДИТХСТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу СЕХ-ны 2025 оны төсвөөс СЕХ-ний Тамгын газрын даргын 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/18 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны зардлыг хуваарилан зарцуулсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны Тамгын газрын 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 3/197 дугаар албан бичиг, 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 3/217 дугаар албан бичиг, 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын хуваарь батлах тухай” албан бичгээр тус тус аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүжилтийн хуваарь, тайлбарыг хавсралтаар хүргүүлсэн байна.

СЕХ-ны тамгын газрын даргын тушаалаар Төв аймагт орон нутгийн сонгууль зохион байгуулах зардалд 139,611.6 мянган төгрөг хуваарилсан байна.

Хүснэгт 1. Нөхөн сонгуулийн зардлын төсөв

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	348,000
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	18,182,000
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	980,000
4	Дүн мэдээ дамжуулах зардал	5,550,000
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	2,100,000
6	Сургалт, сурталчилгааны зардал	4,900,000
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	87,707,200
8	Бичиг хэргийн зардал	1,950,000
9	Шуудан холбооны зардал	2,600,000
10	Унааны зардал	6,720,000
11	Албан томилолтын зардал	8,574,400
ДҮН		139,611,600

Эх сурвалж: СЕХ-ны Тамгын газрын даргын 2025 оны 3/273 дугаар албан бичгийн хавсралт

СЕХ нь орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс олгох зардлын талаар орон нутгийн байгууллагаас урьдчилан тооцсон судалгаа, зардлын төсвийн төслийн санал авдаггүй байна.

СЕХ-оос ирүүлсэн санхүүжилтийг 6 сумын сонгуулийн хороонд зарцуулахаар хуваарилан олгосон байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны тамгын газар нь улсын төсвөөс олгох сонгуулийн хорооны зардлын төсөв болон санхүүжилтийн зарцуулалтын тухай

тайлбар, аргачлалыг тухай бүрд албан бичгээр ирүүлж, санхүүжилтийг сумдын сонгуулийн хорооны харилцах дансанд шилжүүлсэн байна.

Сонгуулийн Ерөнхий хороо нь нийт 139,611.6 мянган төгрөгийн санхүүжилт хийж 6 суманд хуваарилан олгожээ. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хуваарь

/төгрөгөөр/

№	Сонгуулийн хорооны нэр	Хэсгийн тоо	Төсөв
1	Заамар /Төв/	1	18,863,200
2	Лүн /Төв/	1	18,967,200
3	Өндөрширээт /Төв/	1	19,090,400
4	Угтаалцайдам /Төв/	1	18,997,600
5	Эрдэнэ /Төв/	1	30,331,600
6	Эрдэнэсант /Төв/	2	33,361,600
НИЙТ ДҮН		7	139,611,600

Эх сурвалж: Сонгуулийн хорооны мэдээ

Бүлэг 2. СЕХ-ний баталсан журмын дагуу сумдын сонгуулийн хорооны зардлын төсөв, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Нөхөн сонгууль зохион байгуулалттай холбоотой батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 9,180.3 мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос 3-н удаагийн шилжүүлгээр нийт 139,611.6 мянган төгрөгийг баталсан төсвийн хуваарийн дагуу сумдын сонгуулийн хорооны харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн Сонгуулийн хороо байгуулагдаагүй тул СЕХ-оос төсвийн зарцуулалтын тайлбарын дагуу сумдын сонгуулийн хороодод төсвийг хуваарилан шилжүүлж, тухай бүрд арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна.

Сумдын сонгууль зохион байгуулахаар ирүүлсэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг аудитын явцад анхан шатны баримт материалаас түүвэрлэн шалгалаа. Нөхөн сонгууль зохион байгуулсан 6 сумдаас 5 сумын сонгуулийн хороо нь төсвийг хэмнэлттэй зарцуулснаар 9,180.3 мянган төгрөгийг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны Төрийн сангийн 100900022001 дугаарын дансанд буцаан шилжүүлсэн байна.

Төв аймгийн нөхөн сонгууль явуулсан 6 сумын сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайлангаар нийт 139,611.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр 130,431.2 мянган төгрөг зарцуулж, 9,180.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр зардлыг эдийн засгийн ангиллаар тайлагнасан байна.

Хүснэгт 3. Нөхөн сонгууль зохион байгуулсан 6 сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	348,000.00	348,000.00	-
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	18,182,000.00	9,977,090.00	8,204,910.00
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	980,000.00	837,680.00	142,320.00
4	Дүн мэдээ дамжуулах зардал	5,550,000.00	5,470,850.00	79,150.00
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	2,100,000.00	2,100,000.00	-
6	Сургалт, сурталчилгааны зардал	4,900,000.00	4,900,000.00	-
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	87,707,200.00	87,530,800.00	176,400.00
8	Бичиг хэргийн зардал	1,950,000.00	1,950,000.00	-
9	Шуудан холбооны зардал	2,600,000.00	2,600,000.00	-
10	Унааны зардал	6,720,000.00	6,720,000.00	-
11	Албан томилолтын зардал	8,574,400.00	7,996,800.00	577,600.00
НИЙТ ДҮН		139,611,600.0	130,431,220.0	9,180,380.0

Эх сурвалж: Сонгуулийн хорооны мэдээ

Сумдын сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайлангаар хэмнэгдсэн зардлыг авч үзвэл сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татсан зардал 8,204.9 мянган төгрөг, сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарсан зардал 142.3 мянган төгрөг, дүн мэдээ дамжуулах зардал 79.1 мянган төгрөг, сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал 176.4 мянган төгрөг, албан томилолтын зардал 577.6 мянган төгрөг, нийт 9,180.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Орон нутгийн нөхөн сонгуулийн зардлын гүйцэтгэл, тайлагналттай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/33 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.10-т заасны дагуу "Сонгуулийн ерөнхий хороо нь дотоод аудит болон Төрийн сан, орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина." гэсэн заалтыг мөрдлөг болгон ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хороо байгуулагдаагүй тул СЕХ-оос сумдын төсвийн хуваарилалтыг хийж, зарцуулалтад хяналт тавьж, тайланг нэгтгэн Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. СЕХ-ны Тамгын газар нь улсын төсвөөс олгох 139,611.6 мянган төгрөгийн сонгуулийн зардлын төсөв болон зарцуулалтын тухай тайлбарыг албан бичгээр ирүүлж, арга зүйгээр ханган ажиллажээ.
2. Нөхөн сонгууль зохион байгуулсан 6 сумын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 9,180.3 мянган төгрөгийг СЕХ-ний дансанд буцаан төвлөрүүлсэн байна.
3. СЕХ-ний баталсан журмын дагуу сумдын сонгуулийн хорооны зардлын төсөв, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ТАМГЫН ГАЗАР

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141

Утас: (976-51) 26 09 75

Цахим шуудан: gecm@gec.gov.mn

Цахим хуудас: www.gec.gov.mn

2025.09.16 № 3/387

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэгт заасны дагуу Төв аймгийн Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн зардалд хийсэн Нийцлийн аудитын тайланд өгөх саналгүй болно.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



1525050294